



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосон Очирт Хайрхан ОНӨААН-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/03/СТА-ОНӨААН**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenbuyantseren@gmail.com</p> <p>Гэрээт аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
Асуудал тодорхойлогдоогүй.....	Error! Bookmark not defined.
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт.....	10
4.1 Залруулсан алдаа байгүй.	11
4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.....	11
4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.	11
4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ТОСОН ОЧИРТ ХАЙРХАН
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.БАТЖАРГАЛ-д

№ _____
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосон Очирт Хайрхан ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Тосон Очирт Хайрхан ОНӨААН -ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>96197172.04</u>	<u>129688070.87</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1520235.03	12337512.02
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1520235.03	12337512.02
3121	Төгрөг	1520235.03	12337512.02
31213	Арилжааны банк дахь харилцах	1520235.03	12337512.02
33	АВЛАГА	44948030.35	60317814.55
33401	Дансны авлага /ТӨҮГ/	41519074.30	59717027.20
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	3311032.05	600787.35
34	УРЬДЧИЛГАА	1017974.09	1012600.00
3471	Урьдчилгаа тооцоо	1017974.09	1012600.00
34713	Цалингийн урьдчилгаа	1017974.09	1012600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48710932.57	56020144.30
354	Хангамжийн материал	48710932.57	56020144.30
35410	Бичиг хэргийн материал	15000.00	442680.00
35420	Аж ахуйн материал	48149272.57	54311324.30
35470	Бусад хангамжийн материал	546660.00	1266140.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4406718827.69</u>	<u>4237898571.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4406718827.69	4237898571.21
392	Биет хөрөнгө	4406718827.69	4237898571.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	1087246235.75	1095850545.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	-67797964.08	-84711095.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78993300.00	78993300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-45771452.66	-54286240.16
39205	Машин тоног төхөөрөмж	4311133204.00	4325732454.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-959009390.98	-1129825759.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2550000.00	3976263.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-736666.84	-864166.87
39214	Бусад үндсэн хөрөнгө	255000.00	3460400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-143437.50	-427130.39
39301	Програм хангамж	3960000.00	3960000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3960000.00	-3960000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4502915999.73</u>	<u>4367586642.08</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>82839927.06</u>	<u>36045073.88</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	82839927.06	36045073.88
413	Өглөг	82839927.06	36045073.88
4136	Бусад өглөг	81714061.28	36045073.88
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	48731437.32	9813638.82
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	4832023.67	3446320.06
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	28150600.29	22785115.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4420076072.67</u>	<u>4331541568.20</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	4420076072.67	4331541568.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5343917985.00	5343917985.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	5343917985.00	5343917985.00
512	Хуримтлагдсан үр дүн	-923841912.33	-1012376416.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-821583119.32	-921012220.95
51220	Тайлант үеийн үр дүн	-102258793.01	-91364195.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4502915999.73</u>	<u>4367586642.08</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	(3,848,916.44)	23,582,839.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	(3,848,916.44)	23,582,839.10
120	Нийтлэг татварын бус орлого	(3,848,916.44)	23,582,839.10
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	535,548,533.03	624,289,832.58
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	(637,996,258.28)	(600,706,993.48)
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	98,409,783.56	114,947,034.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,409,783.56	114,947,034.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,409,783.56	114,947,034.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,409,783.56	114,947,034.95
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	98,359,800.00	114,597,854.95
210813	Бусад зардал /ТӨҮГ/	44,300.00	349,180.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(102,258,700.00)</u>	<u>(91,364,195.85)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(102,258,700.00)</u>	<u>(91,364,195.85)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,343,917,985.00	-859,939,116.26	4,483,978,868.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	38,355,903.93	38,355,903.93
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,343,917,985.00	-821,583,212.33	4,522,334,772.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00

C07	Тайлант үеийн үр дүн		-102,258,700.00	-102,258,700.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,343,917,985.00	-923,841,912.33	4,420,076,072.67
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,343,917,985.00	1,026,100,612.33	4,420,076,072.67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	2,829,691.38	2,829,691.38
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,343,917,985.00	-921,012,220.95	4,422,905,764.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
D08	Тайлант үеийн үр дүн		-91,364,195.85	-91,364,195.85
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,343,917,985.00	1,012,376,416.80	4,331,541,568.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	559,840,668.36	650,428,738.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	559,840,668.36	650,428,738.80
120	Нийтлэг татварын бус орлого	559,840,668.36	650,428,738.80
120009	Бусад орлого	99,385,233.83	29,107,974.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	460,455,434.53	621,274,371.80
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/		46,393.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	539,172,289.33	637,663,061.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,172,289.33	637,663,061.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,172,289.33	637,663,061.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,893,086.20	203,179,761.24
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	170,893,086.20	203,179,761.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,332,466.27	69,514,330.43
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	52,332,466.27	69,514,330.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,599,126.95	66,657,811.79
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	48,599,126.95	66,657,811.79
2104	Хангамж, бараа материалын зардал	109,515,400.00	194,408,250.18
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	13,493,300.00	31,759,248.00

210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	96,022,100.00	162,649,002.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,832,209.91	103,902,908.17
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	37,390,700.00	61,186,084.83
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	120,280,544.91	42,716,823.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>20,668,379.03</u>	<u>12,765,676.99</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,948,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,948,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,948,400.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		1,948,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-</u>	<u>(1,948,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,668,379.03	10,817,276.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,946,127.90	1,520,235.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,520,235.03	12,337,512.02

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тосон Очирт Хайрхан ОНӨААН -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Б.Дагвасүрэн нар хэрэгжүүлсэн.

Тосон Очирт Хайрхан ОНӨААН-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 11-ний өдрийн 3/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тосон Очирт Хайрхан ОНӨААН нь Тосонцэнгэл сумын ард иргэдийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр ус, дулаанаар найдвартай хангаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, стандартын дагуу цэвэрлэж байгальд нийлүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосон Очирт Хайрхан ОНӨААН-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 722.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Эргэлтийн хөрөнгө	96,197.1	129,688.0	-33,490.9
5	Үндсэн хөрөнгө	4,406,718.80	4,237,898.50	168,820.30
3	Нийт хөрөнгө	4,502,915.90	4,367,586.60	135,329.30
4	Өр төлбөр	82,839.9	36,045.0	46,794.90
5	Эзний өмч	4,420,076.0	4,331,541.6	88,534.40
6	Нийт өр төлбөр эзний өмчийн дүн	4,502,915.90	4,367,586.60	135329.30

Эргэлтийн хөрөнгийн дүн 33,490.9 мянган төгрөгөөр өссөн нь авлагын өсөлттэй холбоотой байна.

Эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл 168,820.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 46,794.9 мянган төгрөгөөр буурсан нь өрөө төлж барагдуулсантай холбоотой үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 88,534.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн ашиг буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 650.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 650.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 1,520.2 мянган төгрөг байсан бөгөөд гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого 650,428.7 мянган төгрөгийн орлого олж урсгал үйл ажиллагаанд 637,663.0 мянган төгрөгийг, хөрөнгө оруулалтын мөнгөн зардалд 1,984.4 мянган төгрөгийг зарцуулж, 12,337.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Анхан шатын баримтгүй гүйлгээ хийсэн, зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 59 мэдээлэл, хугацаа хоцроосон 90 мэдээлэл байна. Аудитын явцад шилэн дансны мэдээллийг засаж оруулсан тул хугацаа хоцроосон мэдээллээр бүртгэгдсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдэлт

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.5 сая төгрөгийн 4 алдаа илрүүлсэнээс 0.47 сая төгрөгийн 2 алдааг залруулж 2.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 0.7 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

- 0.2 сая төгрөгийн томилолтын мөнгө илүү олгосныг тухайн ажилтаны цалингаас суутган авч байгууллагын дансанд төвлөрүүллээ.
- 0.2 сая төгрөгийн жолоочийн торгуулийг үндэслэх баримтгүй төлсөнийг суутган авч байгууллагын дансанд төвлөрүүлсэн

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Илрүүлэлт:

Зөвшөөрөлгүй 2.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь ТБОНӨТ хууль болон Засгийн газрын 43-р тогтоолыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 0.7 сая төгрөгийн зардлын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээгдэлтэй нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1.	Тосон Очирт Хайрхан ОНӨААН	4	3.5	2	0.4			1	2.4	1	0.7
	Дүн	4	3.5	2	0.4			1	2.4	1	0.7